БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ , ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## НЭГ. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО:

Үйлчлэх хүрээний хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйчилгээ болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, тасралтгүй хүргэж, хүн амын эрүүл мэндийн боловсролын түвшинг сайжруулж, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, бие бялдрын чийрэгжүүлэлтийн хувийг дээшлүүлж, эрүүл гэр бүл, иргэн, өрхийн тоог нэмэгдүүлэхэд оршино.

## ХОЁР. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТУУД

**Зорилт 1**: Чанар аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, тусламж үйлчилгээний чанар-аюулгүй байдлыг тасралтгүй хэмжиж сайжруулах

**Зорилт 2**: Чанар сайжруулах арга хэрэгсэл нэвтрүүлж, хэрэгжүүлэх түгээн дэлгэрүүлэх

**Зорилт 3**: Хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх

**Зорилт 4**: Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх

**Зорилт 5:** Үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг хөгжүүлэх

**Зорилт 6**: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, хянах, тогтолцоог олон улсын жишигт ойртуулах

**Зорилт 7**: Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, эрсдлийг бууруулах

## ГУРАВ.ТӨЛӨВЛӨГӨӨ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА:

2024 оны 03 сарын 12-ны өдрөөс 2026 оны 03 сарын 12-ны өдөр хүртэл 2 жилийн хугацаатай хэрэгжинэ.

## ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ,ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ШААРДАГДАХ НӨӨЦ

## ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Үйл ажиллагааны чиглэл | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | 2024 он | 2025 он | 2026 он | Хүрэх үр дүн | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт1: Чанар-аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлыг тасралтгүй хэмжиж сайжруулах | | | | | | | | |
| 1.1 | Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал эрсдлийн баг байгуулж шинээр журам боловсруулж орон тооны бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлж судалгаа, дүн шинжилгээ хийж ажиллах | Тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал эрсдлийн багийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж багийн ажиллах журам боловсруулан хэрэгжүүлэх | * | Шинэч-лэх шаард-лагатай үед | Шинэч-лэх шаард-лагатай үед | Тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал эрсдлийн багийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж журмын дагуу ажиллана | ЭМСайдын 2019 оны А/565тоот тушаалын хэрэгжилтийг ханган Байгууллагын даргын 2025 оны 05 дугаар сарын тушаалаар 5 гишүүнтэй ЭМТҮЧАБ багийг байгуулж, багийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулан үйл ажиллагаа ашиглаж багийн үйл ажиллагааг тогтолмжуулаад байна. | 100 |
| | | Орон тооны бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлж, судалгаа дүн шинжилгээ хийж ажиллах | * | Орон тооны бус гишүүн 2-р нэмэх | Орон тооны бус гишүүн 2-оор нэмэх | Орон тооны бус гишүүдийг нэмж үйл ажиллагааг сайжирна | ЭМСайдын 2019 оны А/565 тоот тушаалын дагуу байгууллагын чанарын багийн орон тооны зөвлөлийг байгуулахдаа орон тооны бус багийг 5 гишүүнтэй батлан гаргасан ба гишүүд ЭТҮЧАБбагийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилладаг. | 100 |
| | | Чанар аюулгүй байдлын багийн гишүүдийн албан тушаалын тодорхойлолтод чиг үүргийг хэрэгжүүлэрээр тусган батлах | * | Шинэчлэгдсэн тохиолдолд | Шинэчлэгдсэн тохиолдолд | Чанар аюулгүй байдлын багийн гишүүдийн албан тушаалын тодорхойлолтод чиг үүргийг тусгагдана | ЭМТҮЧАБ багийн орон тооны болон орон тооны бус гишүүд, ажилчдын албан тушаалын тодорхойлолтод эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах үйл ажиллагаанд оролцож байх чиг үүргийг тусган өгч улиралын урамшуулалт цалингийн үнэлгээний шалгуурт оруулснаар ажилчдын ажлын хариуцлага нэмэгдсэн.<br>Ажилчдын ажлын үр дүнг сайжруулах чиглэлээр ажил дүгнэх шалгуурыг шинэчлэн 2024, 2025 оны эхний 3 улиралд улирал бүр ажилчдын ажлын үр дүнг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дүгнэж жилласан ба 2025 оны 04 дүгээр улиралд сар бүр ажлыг дүгнэж хэлэлцэж ажилчдад танилцуулж ажилласан. | |
| 1.2 | Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг хангах, үнэлэлт дүгнэлт өгөх, түүний мөрөөр цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын төлөвлөгөө гарган батлуулах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангана | - Байгууллагын даргын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс их эмч Б.Төмөрийг чанарын менежерээр томилж, 05 дугаар сарын 07-ны өдрийн А/17 дугаар тушаалаар чанарын багийн гишүүдийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан.<br>- Эмнэлгийн тусламж үйлчилгээний үйл ажиллагаанд удирдамжтай 7 удаагийн хяналт, явцын хяналтыг 31 удаа хийснээр - Тохиолдол 1А- 7 - Алдах дөхсөн тохиолдол 1Б-2 - Таагүй тохиолдол 1 тус тус илрүүлэн тухай бүрд арга хэмжээг аван ажиллаж байна | 100 |
| | | Чанар аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр дүгнэж үр дүнг тооцож тайланг тухай бүрт НЭМГ-т хүргүүлэх | 12 сарын 10-ны дотор | 12 сарын 10-ны дотор | 12 сарын 10-ны дотор | Чанар аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцож үнэлгээ хийлгэсэн байна | Чанар аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гарган байгууллагын удирдлага болон удирдах багийн гишүүдэд танилцуулж ажилласан ба хэлэлцүүлж цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлийг тодорхойлж ажиллаж хэвшүүлсэн. | 100 |
| 1.3 | Чанар, Дотоодын хяналтын багийг томилон үйл ажиллагааг тогтмолжуулж хяналтын төлөвлөгөө, график боловсруулан батлуулж | Дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган баталгаажуулах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Дотоод хяналтын үйл ажиллагаа тогтмолжиж сайжрана | Дотоод хяналтын ажилтанг байгууллагын даргын тушаалаар томилон ажиллуулдаг ба дотоод хяналтын 2024 оны 5 зорилт 26 ажил бүхий төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан байна.<br>Үүнд: Засгийн газрын 89 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган байгууллагын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, түүнд хийх хяналт-шинжилгээг хуваарийн дагуу 8 удаа зохион байгуулсан. Хяналт шалгалтаар илэрсэн 12 зөрчлийг цаг хугацаанд нь арилгах талаар зөвлөгөө өгч | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналтын дэвтэр хөтлөн тогтмол хяналт хийж Монгол улсын засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах | | | | | | үр дүнг тооцож ажилласан. Ноцтой зөрчил дутагдал бүртгэгдээгүй.<br>Засгийн газрын 89 дүгээр тогтоолыг байгууллагын удирдлагын багийн гишүүд болон эмч нарт танилцуулах цахим сургалтыг 2 удаа, танхимын сургалтыг 1 удаа тус тус зохион байгуулсан.<br>2024 онд хяналт-шинжилгээг хуваарийн дагуу 9 удаа зохион байгуулсан. Хяналт шалгалтаар илэрсэн 10 зөрчлийг цаг хугацаанд нь арилгах талаар зөвлөгөө өгч үр дүнг тооцож ажилласан.<br>Байгууллагын үйл ажиллагаанд өглөө ээлж солих бүрт явцын хяналтыг хийж тогтмолжуулсан ба зөрчил дутагдлыг тухай бүр нь залруулж ажилласан.<br>-Байгууллагын даргын 2025 оны А/54 дүгээр тушаалаар 23 нэгжид дэмжлэгт хяналтыг 2 удаа зохион байгуулж нийт 19 зөрчлийг арилгуулж бэлэн байдлыг хангаж ажилласан.<br>Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа болон хэрэгжиж байгаа хөтөлбөр, төлөвлөгөө, тушаалын шийдвэрийн хэрэгжилтэнд хагас бүтэн жилд хийж удирдлагын багийн хурлаар оруулж цаашид хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж тодотгол хийж ажиллаж хэвшсэн. | |
| | | Дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг явуулж, үр дүнг тооцон ажиллах | | | | | Дотоод хяналтын ажилтан хяналт үнэлгээний төлөвлөлтийн дагуу байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа болон хэрэгжиж байгаа хөтөлбөр, төлөвлөгөө, тушаалын шийдвэрийн хэрэгжилтэнд хагас бүтэн жилд хийж удирдлагын багийн хурлаар оруулж цаашид хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж тодотгол хийж ажиллаж хэвшсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4 | Тусламж үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын талаар мэргэжлийн нийгэмлэг холбоод, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, сургалт, судалгаа хийх, туршлага судлах ажлыг зохион байгуулна. | Эрүүл мэндийн чанарын холбоо, НЭМГ-ын Чанарын удирдлагын хэлтэстэй хамтран жилд 1 удаа сургалт зохион байгуулж бүх ажилчдыг хамруулах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Эрүүл мэндийн байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог ойлгодог, хамтран ажилладаг болно. | Тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг сайжруулах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр Яаралтай тусламжийн багийг 6 хүний бүрэлдэхүүнтэй шинэчилэн байгуулан ахлагч Л.Пагмадулам томилон ажиллуулсан. Яаралтай тусламжийн багаас сувилагч болон туслах сувилагч нар амиллуулах суурь тусламж болон лавшруулах тусламжийг сургалтыг 14 хоног тутам заах ажлын байранд дахь дадлагыг 7 удаа зохион байгуулсан байна. Мөн яаралтай тусламжийн өрөөний зохион байгуулалтыг шинэчилэн шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гарган шинэчилэн ажилласан.<br>-Яаралтай тусламжийн цогц менежмент сургалтыг Нийслэлийн түргэн тусламжийн төвтэй хамтран 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулж эмч, сувилагч, ажилчид бүрэн хамрагдсан. Тус сургалтанд 1,950,000 төгрөг зарцуулсан. | 100 |
| | | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал гэж юу вэ сургалтанд ажилчдыг хамруулах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Тусламж үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, талаар мэдлэг, хадлага нэмэгдсэн байна. | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор ЭМСайдын 2017 оны А/514 тоот тушаалаар төлөвлөгөө гарган ажилчдад танилцуулсан ба<br>Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах 6 зорилтын хүрээнд үйлчлүүлэгчдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай цаг алдалгүй сэтгэлд хүрсэн үйлчилгээг хүргэх зорилгоор байгууллагын даргын 2020 оны А/40 дүгээр тушаалаар үйлдэл бүрт үйлчлүүлэгчийг зөв танхих үйл явцыг тодорхойлсон журам боловсруулан баталж өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. | 100 |
| | | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зарчмыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган батлуулах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зарчмыг | | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зарчмыг хэрэгжүүлэн ажиллах арга хэмжээ зохион байгуулах, үр дүнг тооцон ажиллах | | | | хэрэгжилт хангагдана | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж Үйлчлүүлэгчийг зөв таних нийт 5 төрлийн журамтай ба Амбулаторийн хэсэг, Хэвтэн эмчлүүлэх хэсэг тус бүрийн үйл ажиллагаанд тохирсон байдлаар боловсруулан гаргаж, үйлчилгээ үзүүлэхэд тогтмол ашиглаж байна. Үүнд:<br>1. Унах эрсдэлтэй үйлчлүүлэгчтэй харилцах<br>2. Хэлгүй, дүлий харилцахад бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй харилцах<br>3. Тулгуур эрхтэний бэрхшээлтэй иргэнтэй харилцах,<br>4. Ижил нэртэй үйлчлүүлэгчийн таних<br>5. Харшилтай үйлчлүүлэгчийн таних журмуудыг боловсруулан таних тэмдэг ашиглан үйл ажиллагаандаа хэрэгжүүлээд байна.<br>Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал зөв танхим журмын дагуу ажилчдад танилцуулах сургалтыг 2024 онд 2 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 30 ажилчид хамрагдсан ба албан бусаар буюу өдөр тутамд сануулах ярилцах байлдаар ажлын байран дээрхи сургалт зөвлөгөөг тогтмол өгөн ажиллаж байна.<br>2024 онд байгууллагын Чанарын багаас 1 удаа, Эрүүл мэндийн чанарын холбоонос нэг удаагийн сургалтыг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 35 хамрагдсан. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж дотоод хяналтын ажилтан 3 удаа, чанарын багаас 2 удаа хяналт тавьж гарсан алдаа зөрчлийг тухай бүр арилгах талаар зөвлөмж өгч ажилласан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2025 онд байгууллагын Чанарын багаас 1 удаа, Амилуулах нийгэмлэгтэй хамтран 1 удаа сургалтыг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 38 хамрагдсан.<br>Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж дотоод хяналтын ажилтан 2 удаа, чанарын багаас 2 удаа хяналт тавьж гарсан алдаа зөрчлийг тухай бүр арилгах талаар зөвлөмж өгч ажилласан. | |
| | | Эрсдэлийн удирдлага, эрсдлийн төлөвлөгөөг гарган баталгаажуулах<br><br>Эрсдлийн удирдлага, эрсдлийн бууруулах төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнг тооцох | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Тусламж үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдэлийн талаар мэдлэг, хадлага нэмэгдсэн байна. | Байгууллагын эрсдэлийн төлөвлөгөөг 3 бүлэг 55 заалттай гарган баталгаажуулсан ба эрсдлээс сэргийлэн ажиллаж, эмч эмнэлгийн ажилчдад сургалтыг хийж эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний биелэлтийг хanган ажиллаж байна. | 100 |
| Зорилт 2: Чанар сайжруулах арга хэрэгсэл нэвтрүүлж, хэрэгжүүлэх түгээн дэлгэрүүлэх | | | | | | | | |
| 2.1 | Төвийн үйл ажиллагаа, үзүүлж буй тусламж, үйлчилгээнд тохирсон чанар, аюулгүй байдлыг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан батласан, хэмжилт үр дүн | Тусламж үйлчилгээтэй холбоотой шалгуур үзүүлэлтийг боловсруулан батлуулах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Тусламж, үйлчилгээнд тохирсон чанар, аюулгүй байдлыг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан батласан байна | Тусламж үйлчилгээний чиглэл бүрээр хэмжих шалгуур үзүүлэлт боловсруулан гарган батлуулсан байна.<br>Үүнд: - Амбулаторийн тусламж үйлчилгээг үнэлэх шалгуур үзүүлэлт<br>- Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг үнэлэх шалгуур үзүүлэлт<br>- Дотоод эмийн сангийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт<br>- Хүлээн авах яаралтай тусламжийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт<br>- Дархлаажуулалтын үйл ажиллагаанд хяналт хийх шалгуур үзүүлэлт | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шинжилгээ хийдэг байх | | | | | | - Амбулаторийн үйл ажиллагаанд хяналт хийх шалгуур үзүүлэлт<br>- Лабораторийн үйл ажиллагаанд хяналт хийх шалгуур үзүүлэлт<br>Эдгээр нэгжийг үнэлэх шалгуур үзүүэлтүүдийг гарган батлуулсан. | |
| | | Тусламж үйлчилгээтэй холбоотой шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт үнэлгээ хийж, үр дүнг тооцон, засаж сайжруулах арга хэмжээ авах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | хэмжилт үр дүн шинжилгээ хийдэг болсон байна | Хүлээн авах, Яаралтай тусламж Түргэн тусламжийн үйлчилгээг 14 төрлийн хяналтын хуудас, Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг 8 төрлийн хяналтын хуудас, Амбулаторийн тусламж үйлчилгээнд 9 төрөл, гардан үйлдэл тусламж үйлчилгээг 18 төрлийн шалгуур хуудсаар хяналт үнэлгээг хийсэн.<br>Гарсан дүгнэлтийг бүх ажилчдад танилцуулан, алдаа зөрчлийг нь засаж үйл ажиллагаандаа ашиглаж, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээ авч ажилладаг. | 100 |
| 2.2 | Үзүүлж буй тусламж , үйлчилгээнд гарч буй тулгамдсан асуудал,аюулгүй байдал алдагдсантай холбоотой тохиолдлын шалтгаан илрүүлэх, сайн туршлага түгээн дэлгэрүүлэх | Чанар сайжруулах арга хэрэгсэл гэж юу вэ?, хэрхэн үйл ажиллагаандаа ашиглах вэ? сургат хийх | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Чанар сайжруулах аргуудыг ойлгосон үйл ажиллагаандаа ашигладаг болно. | Чанар сайжруулах арга хэрэгсэлийн тухай сургалтад эмч эмнэлгийн ажилчдыг 2 удаа хамруулж нэг удаад нь Монголын Эрүүл мэндийн чанарын холбооноос сургагч багшийн сургалтад хамруулсан. | 100 |
| | | Чанар сайжруулах аргаас асуумж судалгаа, фокус ярилцлага, өрнөлийн зураглал гаргах, чанар сайжруулах хэрэгслүүдээс Яагаад яагаад, нөөц ашиглалт, хяналт шинжилгээхийх зэрэг арга хэрэгсэлүүдийн | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Чанар сайжруулах аргаас асуумж судалгаа, фокус ярилцлага, өрнөлийн зураглал гаргах гэх мэт чанар сайжруулах | Байгууллагын чанар сайжруулах арга хэрэгсэлд<br>- фокус ярилцлага- 6 удаа<br>- Үйлчлүүлэгчид болон эмч ажилчдаас сэтгэл ханамжийн судалгааг цаасаар авч<br>- Тохиолдол бүртгэгдсэн тохиолдолд өрнөлийн зураглал гаргах арга хэрэгсэл ашиглан ажиллаж байна.<br>Чанар сайжруулах арга хэрэгслийн ашигланаас нэг тохиолдол дээр нэг хүн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ашиглалтыг сайжруулах | | | | арга хэрэгсэл ашиглалт сайжрана | буруутай байдаггүй ба багаар ажиллах нь хэрхэн үр дүнтэй байх, дээрхи арга хэрэгслүүд нь үйлчлүүлэгч болон эмч эмнэлгийн ажилчдыг аюулаас сэргийлэх үр дүнтэй байдгыг ойлгож ажиллаж байна. | |
| | | Байгууллагын эмх цэгц соёлыг түгээн дэлгэрүүлэх 5 S зарчим нэвтрүүлэх | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Байгууллагын эмх цэгц соёл сайжирснаар ажилчдын эмх цэгц соёл сайжрана | Байгууллагын хэмжээнд эмх цэгц соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор бүх ажилчдын дунд 5S зарчмыг хэрэгжүүлснээр ажилчид өөр өөрийн ажлын байрыг сайжруулах цэвэр цэгцтэй байх эрмэлзэлтэй болсон. | 100 |
| Зорилт 3: Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх | | | | | | | | |
| 3.1 | Тусламж үйлчилгээний аюулгүй байдал алдагдсантай холбоотой бүртгэгдсэн тохиолдлын шалтгаанд дүн шинжилгээ хийж, давтан гарахаас сэргийлэн эмч, ажилтанг чадахижуулах, сургах хүний нөөцийн бодлогийн үйл ажиллагааг сайжруулах | Хүний нөөцийн үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган батлуулах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Хүний нөөцийг чадавхжуулах төлөвлөгөөтэй болно | Хүний нөөцийг хөгжүүлэх 2021-2025 онд хэрэгжүүлэх 6 бүлэг 18 заалттай хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажилласан. Хөтөлбөрийн биелэлтийг жилээр гаргаж байгууллагын удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлж дүгнэлт хийж ажилласан ба хэрэгжилт 96,7%-тай хэрэгжсэн.<br>Эмнэлгийн мэргэжилтний хөгжил, давтан сургалтын төлөвлөгөөг 2 жилээр төлөвлөн баталдаг ба 2024-2025 онд нийт 16 заалттай төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.<br>2024 оны мөн үетэй харьцуулахад хэрэгжилт 2,2 хувиар нэмэгдсэн.<br>Эмч, эмнэлгийн ажилтны мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ЭМЯ, НЭМГ болон бусад байгууллагаас цахимаар зохион байгуулсан 31 удаагийн сургалт, танхимаар зохион байгуулсан 49, нийт 80 удаагийн сургалтад давхардсан тоогоор 123 эмч, эмнэлгийн ажилтныг хамруулав.<br>Дүүргийн Эрүүл мэндийн төвөөс дотоод сургалтыг цахимаар 6 удаа, танхимаар | |
| | | Хүний нөөцийг чадавхжуулах гадаад , дотоод сургалтын төлөвлөгөө гарган батлуулах | | | | | | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 18 удаа зохион байгуулж, ажилчин, албан хаагчдыг бүрэн хамруулсан байна.<br>БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын Олон улсын Монгол эмнэлгийн хороотой хамтран хэрэгжүүлж буй "Хятад-Монголын сувилагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх" олон улсын 7 хоногийн сургалтад удирдах ажилтан Х.Ганбат, бариач, туслах сувилагч С.Олзбаяр их эмч М. Төмөрчөдөр нар нийт 3 ажилтан 4,7,8 сард үе шаттайгаар явж сургалтанд хамрагпсан. | |
| | | Хүний нөөцийн ажиллах тав тухтай аюулгүй орчинг бүрдүүлэх | | | | Эмч эмнэлгийн ажилчид ажиллах таатай аюулгүй орчиноор хангагдаж, ажиллах урам зорилгтой байна | Амбулаторийн Угтах үйлчилгээний ажилтанг ажиллах тав тухтай орчинг бүрдүүлж тек ширээ хийж байршуулсан. Мөн угтах үйлчилгээний ажилтан ажиллах баримтлах журмыг боловсруулах мөрдлөгө болгон ажиллуулж байна.<br>Ажилчдын ажиллах нөхцлийг сайжруулах ажлын хүрээнд:<br>- Өвчний түүхийг бүрэн цахимжуулж, цаасан суурьт өвчний түүхгүй болгосон. | 100 |
| Зорилт 4: Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх | | | | | | | | |
| 4.1 | Нотолгоонд суурилсан анагаах ухааны ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх, үйл ажиллагаанд аа ашиглах | Хэвлийн хэт авиан шинжилгээг тогтмол хийдэг болох | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Иргэдэд хэвлийн хэт авиан шинжилгээг хийж, чирэгдэлгүй тусламж үйлчилгээг үзүүлдэг болно. | Дүрс оношилгооны эмч Эрт илрүүлгийн үзлэг шинжилгээ болон амбулатори, яаралтай тусламжийн үед Хэвлийн хэт авиан шинжилгээг хийн ажиллаж байна.<br>2025 онд онош зүйн хэсгийн хэт авиан оношлогоонд 446, рентген оношлогоонд 489 хүн, зүрхний цахилгаан бичлэг 1324 нийт 2159 оношлогоог дүүргийн эмнэлэгтээ хийсэн. | 100 |
| | | Рентген шинжилгээг тогтмол хийдэг болох | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Иргэдэд Рентген шинжилгээг | Рентген шинжилгээг тогтмол ажиллуулж хэвийн үйл ажимллагааг хангах зорилгоор 2024 онд 1 удаа, 2025 онд 2 удаа | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хийж, чирэгдэлгүй тусламж үйлчилгээг үзүүлдэг болно. | мэргэжлийн байгууллагаар засвар үйлчилгээг хийлгэсэн. | |
| | | Лабораторийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэнэ | Лабораторийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж нийслэлийн хөрөнгө оруулалтаар 23 сая төгрөгний цусны аппарат, дүүргийн хөрөнгө оруулалтаар 38,5 сая төгрөгөөр биохимийн бүрэн автомат аппаратыг тус тус шийдвэрлүүлсэн.<br>Өдөрт 15 хүнд биохимийн шинжилгээг хийж байна. Биохимийн шинжилгээний үзүүлэлт нэмэгдсэнээр хүүхэд болон насанд хүрэгчдийн тусламж үйлчилгээнд ахиц дэвшил гарсаар байна. | 100 |
| | | Шинэ Эмийн эмчилгээний сургалт мэдээллийн хийх | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Эмч сувилагч нарын мэдлэг мэдээлэл нэмэгдэж, эмчилгээ үйлчилгээний чанар сайжрана | Эмч сувилагч нар өөр хоорондоо шинэ эмийн мэдээллийг хийж ажилладаг. Эм зүйг хороонoос зөвлөгөө авч ажилладаг.<br>Нийт 7 удаагийн шинэ эмийн мэдээлэл хүргэгдсэн байна. | 100 |
| | | Эмч сувилагч нарт эмчилгээ оншилгооны түгээмэл үйлдлийн стандартын дагуу өөрийн эмнэлэгт ховор тохиолддог гардан ажилбарыг хийж чаддаг болох | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Эмч сувилагч нарын мэдлэг мэдээлэл нэмэгдэж, эмчилгээ үйлчилгээний чанар сайжрана | 2024-2025 онд Ходоод угаах ажилбар 2 удаагийн тохиолдол, хэвлийн хөндийн ус авах ажилбар 2 удаа, сэхээн амьдруулах тусламж үйлчилгээ 4 удаа тохиолдсон ба Ходоод угаах, хэвлийн хөндийн хатгалт хийх зэрэгт эмч сувилагч нарыг байлцуулан ажлын байранд сургалт хийсэн. | 100 |
| | | Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Эмч сувилагч | Байгууллагын хэмжээнд мөрдөн ажиллаж байгаа стандарт дүрэм журмын | 95 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | буй стандарт удирдамжийн сургалт хийх | | | | нарын мэдлэг мэдээлэл нэмэгдэж, эмчилгээ үйлчилгээний чанар сайжрана, аюул, эрсдэлгүй ажиллах нөхцөл бүрдэнэ | жагсаалтыг шинэчлэн гарган байгууллагын даргын 2025 оны А/43 дугаар тушаалаар батлуулж эмч ажилчдад танилцуулан ажлын байрны 4 удаа сургалтыг хийж ажиллаж байна. | |
| | | Шинэ ирсэн болон бусад тоног төхөөрөмжийн сургалтыг тогтмолжуулах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Эмч сувилагч нарын мэдлэг мэдээлэл нэмэгдэж, эмчилгээ үйлчилгээний чанар сайжрана, аюул, эрсдэлгүй ажиллах нөхцөл бүрдэнэ | Яаралтай тусламж болон байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа багаж тоног төхөөрөмжийн сургалтыг 2 удаа зохион байгуулсан ба сургалтанд нийт давхардсан тоогоор 43 хүн хамрагдсан.<br>-УХТЭмнэлгийн сургалтанд -13<br>-Дотоод сургалтад -30 ажилчид тус бүр хамрагдсан. | 100 |
| Зорилт 5: Үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээг хөгжүүлэх | | | | | | | | |
| 5.1 | Үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах | Амбулаторийн тусламж үйлчилгээний жагсаалтыг батлан гаргах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Амбулаторийн тусламж үйлчилгээний чиглэл тодорхой байх | Амбулаторийн тусламж үйлчилгээний жагсаалтыг гарган байгууллагын даргаар батлуулсан.<br>Амбулаториор тусламж үйлчилгээ үзүүлэх нийт 90 төрлийн тусламж үйлчилгээний жагсаалт гаргаж тусламж үйлчилгээг хүргэж байна. | 100 |
| | | Амбулаторийн тусламж үйлчилгээний чиглэлээр дуугүй хөтөч ажиллуулах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Иргэдэд мэдээллийг хүргэнэ | Амбулаторийн тусламж үйлчилгээний чиглэлээр дуугүй хөтөч болон хөтөч сувилагч чиглүүлэн, ажиллаж байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Амбулаторийн тусламж үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэх Угтах үйлчилгээний ажилтан ажиллах журмыг боловсруулан батлуулах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Угтах үйлчилгээний ажлын чиг үүрэг тодорхой болж, иргэдэд чирэгдэлгүй тусламж үйлчилгээг хүргэнэ | Амбулаторийн тусламж үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэх зорилгоор угтах үйлчилгээг ажиллуулдаг ба Угтах үйлчилгээний ажилтан ажлын байранд 5 төрлийн журмыг батлуулан мөрдлөг болгон ажилладаг ба журмын хэрэгжилтэнд хөндлөнгийн хяналт үнэлгээ хийж, ажлын байрны зөвлөгөө заавры тогтмол өгөн ажилладаг | 100 |
| | | Угтах үйлчилгээний ажилтан ажиллах журмын хэрэгжилтэнд хяналт хийж үр дүнг тооцон ажиллах | | | | | | |
| | | Үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг тогтмол авах, санал хүсэлт өгөх нөхцөл бололцоогоор хангах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийг сонсоно | Байгууллагын брэнд өнгийн "Ногоон" өнгөөр сонгож амбулаторийн хүлээлгийн хэсэг болон бусад хэсгийг өнгөөр жигдрүүлэн иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох самбар болон видео шторк явуулах зурагт, мөн бага насны хүүхдийг хувцаслах, өлгийдөх бандан зэргээр тохижуулан өнгө үзэмжийг нэмсэн. | 95 |
| | | Санал хүсэлтийн тайланг гаргаж, үр дүнг тооцон, түүнд тулгуурлан арга хэмжээ авч ажиллах | | | | | | |
| | | Амбулаторийн хэсгийн тохижилт, ая тухтай байдлыг хангах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Байгууллагын өнгө үзэмж нэмэгдэнэ. үйлчлүүлэгчид ээлтэй орчин бүрдэнэ | Амбулаторийн хэсэгт иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох 4 төрлийн ханын самбар болон видео хичээл явуулах зурагт байршуулж видео, контент, шторкуудыг тогтмол явуулж хэвшээд байна. | 95 |
| | | Амбулаторийн хүлээлгийн хэсэгт иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох орчинг бүрдүүлэх | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Амбулаториор үйлчлүүлж буй иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох тав тухтай орчин бүрдэж, | | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрүүл мэндийн боловсрол дээшлэнэ. | | |
| Зорилт 6: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, хянах тогтолцоог олон улсын жишигт ойртуулах | | | | | | | | |
| 6.1 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, хянах тогтолцоог олон улсын жишигт ойртуулах | Халдварын сэргийлэлт хяналтын багтай болох | Жилдээ | Жилдээ | Жилдээ | ХСХ багтай болно | Байгууллагын даргын тушаалаар Халдварын сэргийлэлт хяналтын 5 хүний бүрэлдэхүүнтэй багтай болсон. ХСХ-ын асуудал хариуцсан ажилтнаар их эмч Л. Пагмадулам сургаж ажиллуулж байна. ХСХ-ын асуудал хариуцсан ажилтанд үндсэн ажлаас гадна ХСХ-ын үйл ажиллагаанд зарцуулах цагийн зохицуулалт хийсэн. | 100 |
| | | Халдварын сэргийлэлт хяналтын баг үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган батлуулах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | ХСХбагийн төлөвлөгөө хэрэгжинэ | Хяналт, үнэлгээ хийх төлөвлөгөөтэй, хуваарийн дагуу сургагдсан мэргэжилтнүүд хяналт хийсэн. Халдвар хяналтын багийн хяналт хийх төлөвлөгөөг сар бүрээр гаргаж хяналтыг ХСХ-ын асуудал хариуцсан ажилтан улирал тутам, чанарын багийн гишүүд, сувилахуйн багийн гишүүд сар тутамд батлагдсан хяналтын хуудсаар хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж ажилладаг. | 100 |
| | | ХСХ холбоотой дүрэм, журам, халдварын хяналтын ажилтанг сургах, ажилчдад ХСХяналтын талаар сургалт хийх | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Эмнэлгийн эмч ажилчид ХСХ мэдлэг мэдээлэлтэй болно | Тус эмнэлэг нь ХСХ-ын асуудал хариуцсан ажилтантай гэрээгээр бөгөөд ЭМС-ын 2019 оны 536, 537, 538, 539 тоот тушаалуудаар цуврал сургалтыг ажилтнуудад явуулсан. Нийт ажилтнуудад зориулан "Гар угаах, халдваргүйжүүлэх", "Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх", "Хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх, тайлах заавар", "Хог хаягдлын менежмент", "Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй халдвараас сэргийлэх", "Өртөлтийн дараах арга хэмжээ", "Цар тахлын үед ажиллах, хариу арга хэмжээ авах, тусгаарлан сэргийлэлт", | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлчилгээний ажилтнуудад зориулан "Эрүүл мэндийн байгууллагад цэвэрлэгээ хийх" зэрэг сургалт хийсэн. | |
| | | Эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэг удаагийн хэрэгсэлээр тогтмол хангаж, хэрэглээнд хяналт хийх | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас эмч эмнэлгийн ажилчид болон үйлчлүүлэгчид хамгаалагдаж чадна. | 1. Эмнэлгийн хэмжээнд спиртийн найрлага нь70-80 хувь, гарын арьсыг хуурайшуулахаас сэргийлсэн, зөөлрүүлэгчтэй үндэсний болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бодисоор үйлдвэрлэл явуулдаг, үйлдвэрийн гар халдваргүйжүүлэх уусмал хэрэглэж байна.<br>2. 2025 оноос нэг улаагийн спирттэй падыг ашиглан туршилтаар хэрэглэж эхлэж байгаа бөгөөд үр дүн хэрэглээ илүү хялбар бол ашиглаж хэвшүүлэх саналтай байгаа.<br>Улсын бүртгэлд бүртгэгдсэн. Хангалттай нөөцтэй.<br>Гар ариутгагч, цэвэрлэгээний халдваргүйжүүлэгч бодисыг эм эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэгч "Энто", "Нью Ремеди" болон бусад тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудаас гэрээгээр худалдан авалт хийдэг. Цэвэрлэгээний бодисыг батлагдсан зааврын дагуу найруулж, бүртгэл хөтөлдөг. | 100 |
| | | ЭМСайдын А/538 тоот тушаалыг хэрэгжүүлэн олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвараас сэргийлэх, антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэн ажиллах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | | 1. Нянгийн тэсвэржилтийг бууруулж хэрэгжүүлэх журам шинэчлэн баталсан.<br>2. Бүх антибиотикийн ангиллыг гаргаж хязгаарлагдмал, хянах шаардлагатай, бусад гэх мэт нянгийн эрсдэлийн ангиллыг гаргаж антибиотик эмчилгээ үйлчилгээнд авч байна.<br>3. Антибиотик хийх заалт гаргаж, антибиотик мэдрэг чанарыг шаардлагатай тохиолдолд Улаанбаатар хотруу шинжилгээнд илгээж шинжилгээний хариуг үндэслэн эмчилгээг авдаг. | 95 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 4. Манай эмнэлэгт зонхилон хэрэглэдэг антибиотикийн заавар, илрэх гаж нөлөө анхаарах зүйлсийг багтаасан антибиотикийн хавтас нээн ажиллаж байна. АБ эмийн сонголт болон эмчилгээний схем, тун, гаж нөлөөний талаар бэлэн харах материалтай болж мэдлэг сайжирсан. Эм найруулагч зөвийн зарчмыг баримтлан үйлчлүүлэгчдэд эм зүйн тусламж үйлчилгээг үзүүлж байна.<br>5. Өөрийн эмнэлгийн нөхцөлд тохируулан антибиотик эмчилгээний бүртгэлийн дэвтэр нээж, судалгаа хийдэг. Бусад ажилчдад мэдээлэл өгдөг.<br>Хэвтэн эмчлүүлэгч нарт зориулан агуулга бүхий эмийн зохистой хэрэглээний зөв зарчмын сануулгатай гарын авлага, мэдээллийг самбарт байршуулснаар үйлчлүүлэгчдийн эмийн зөв зохистой хэрэглээний мэдлэг сайжирсан | |
| | | ЭМСайдын А/539 тоот тушаалыг хэрэгжүүлэн ажиллах, тандалт хийх /мэс заслын дараах шархны халдварын тандалт, судасны гуурстай холбоотой халдвар, шээлгүүртэй холбоотой халдварыг ирлүүлэх, сургалт зохион байгуулах/ | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой эрсдэлд үйлчлүүлэгчийг оруулахгүй байх, тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас эмч эмнэлгийн ажилчид болон үйлчлүүлэгчид | ЭМСайдын А/539 тоот тушаалын хэрэгжилтийг хангаж “Уян зүүний хяналт” сэдвээр 2 удаагийн хичээл орж, хяналтын хуудсыг хэтлүүлж, мөн өвчний түүхэнд уян зүү тавьсан протокол бичих хуудсыг боловсруулан гаргаж сувилагч нарт хөтлөх арга аргачлалыг заан хөтлөлтийг хэвшүүлээд байна.<br>Мөн тарианы өрөө болон сувилагчийн постонд уян зүүний хяналт анхаарах асуудлаар ханын самбар, гарын авлага хийж байршуулсан. | 95 |
| | | ЭМСайдын А/537 тоот тушаалын 1 дүгээр хавсралтыг хэрэгжүүлэн ажиллах / үзлэгийн өрөө бүрт гарын ариун цэвэр сахих нөхцлийг | Жилдээ | Жилдээ | Жилдээ | | ЭМСайдын А/537 тоот тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор үзлэг болон ажилбар хийгддэг өрөө бүр үйлчлүүлэгчийн өрөө бүр гар угаалтуууртай ба угаалтуур бүрийн ард гар угаах дарааллыг байршуулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүрдүүлсэн байх,крантны ард гар угаах дараалал байршуула, гар угаах нянгийн эсрэг шигэн саван байршуулах, гар арчих нэг удаагийн цаасан алчуур байршуулах/ | | | | хамгаалагдаж чадна. | | |
| | | Эмч эмнэлгийн ажилчдыг В, С вирусын шижилгээнд хамруулж, дархлаажуулалтанд бүрэн хамруулах<br><br>ЭМСайдын 2019 оны А/537 тоот тушаалын 3 дугаар хавсралтын 6 дугаар заалтын дагуу "Өртөлтийн дараах сэргийлэлт" арга хэмжээг авдаг байх | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Эмч эмнэлгийн ажилчдыг эрсдэлээс сэргийлэж чадна | 1. ЭМА-нд хийсэн дархлаажуулалтын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сантай. Эмч, эмнэлгийн ажилчдыг дархлаажуулалтанд хамруулсан бүртгэл мэдээллийн санг 2022, 2023 онуудаар үүсгэсэн.<br>2. Хурц болон архаг халдваргүй, эсрэг заалтгүй эмнэлгийн ажилтан бүрийг В вируст гепатитийн 3 тун вакцинаар дархлаажуулсан.<br>3. Нийт 2 ажилтныг В вируст гепатитын идэвхжил баталгаажуулах шинжилгээнд хамруулсан.<br>Жил бүр үндсэн болон шинээр ажилд орсон эмч ажилчдыг улирлын томуугийн вакцинжуулалтанд хамруулдаг. | 95 |
| **Зорилт 7: Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, эрсдлийг бууруулах** | | | | | | | | |
| | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зорилтийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргах батлуулах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зорилт хэрэгжиж үйлчлүүлэгчид аюулгүй тусламж үйлчилгээг хүргэнэ | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 6 зорилт 13 хэрэгжүүлэх ажил бухий төлөвлөгөөг гарган батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа ба хэрэгжилт 92%-тай хэрэгжсэн. | 95 |
| | | Амбулаториор үйлчлүүлж буй болон эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Үйлчлүүлэгч унах эрсдэлээс | Унаж бэртэхээс сэргийлж байгууллагын хашаа, үүдний хэсэг дэвсгэр дэвсэж мөн зөөлөвч резин нааж хамгаалалт хийж өгсөн. | 95 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлчлүүлэгчдийг унах эрсдээс сэргийлэх арга хэмжээг авах, үр дүнг тооцон ажиллах | | | | хамгаалагдана | Мөн хэвтэн эмчлүүлэгч нарт анхааруулсан хальтиргаа нойтон байгааг харуулсан тэмдэглэгээг байршуулдаг болсон.<br>Хүүхдийн тасгийн орыг бүгдийг хамгаалалттай ортой болгосноор бага насны хүүхэд орноос унах эрсдэлээс бүрэн сэргийлж чадсан.<br>Амбулаторийн хэсэгт ханын бариулыг шинээр хийлгэсэн. | |
| | | Үйлчлүүлэгчид тулгарч болох бие махбодын, соёлын, хэл ярианы болон бусад саад бэрхшээлийг шийдвэрлэх талаар ажилтныг сургаж бэлдэх, хөндлөнгийн саадгүй орчинд асуудлыг шийдвэрлэж үйлчлэх | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Харилцааны бэрхшээлтэй иргэнтэй харилцаж сурах тэдэнд адил тэгш харилцах үйлчилгээ сайжрана. | Харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй харилцахдаа угтах үйлчилгээн дээрээс эхлэн Самбар үзэг ашиглан харилцаа үүсгэн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгаа. | 95 |
| | | ЭМС-ын 2021 оны "Журам заавар батлах тухай" А/814 тоот тушаалын хэрэгжилтийг сайжруулах,<br>Эмч, сувилагч эмнэлгийн ажилтанг Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээ үзүүлэх сургалтанд тогтмол хамруулж чадавхжуулах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээ сайжирч үйлчлүүлэгчид аюул учрахгүй байх | Яаралтай тусламж Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор яаралтай тусламжийн өрөөний зохио байгуулалтыг сайжруулж, өрөөний тохижилтыг хийж яаралтай тусламжийн ханын алгоритмуудийг хийж байршуулахаас гадна, А/814 тоот тушаалын эрэмбэлэн ангилалын хэсгийнсамбар болгон байршуулсан.<br>Мөн яаралтай тусламжийн багаж тоног төхөөрөмжтэй ажиллах сургалтыг 2 удаа авсан байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Яаралтай туслажмийн багаж тоног төхөөрөмжийг ажиглалтын сургалт зохион байгуулах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Яаралтай тусламжийн багаж тоног төхөөрөмжийн ашиглалт сайжрсанаар үйлчлүүлэгчийн аюулгүй байдал сайжрана | Өндөр эрсдэлтэй, ижил харагдах, ижил савлагаатай, ойролцоо дуудлагатай эм тарианы жагсаалт гарган баримтлан ажиллах журам боловсруулан гаргаж эмч эмнэлгийн ажилчдад танилцуулан сургалт хийсэн ба эмийн фондны шкаф болон дотоод эмийн сангийн эмийн шкафанд байрлуулсан.<br>Мөн журмын дагуу эрсдэл бүхий эм тариаг ялгах тэмдэглэгээг хийж хаягжуулсан. | 95 |
| | | Хэвтүүлэн эмчлэх оношилгоо эмчилгээ, үйлдийн жагсаалт гарган батлуулах, стандарт удирдамжийн дагуу мөрдөн ажиллах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Үйлчлүүлэгчийн аюугүй байдал хангагдана | Хүчилтөрөгчийн хийн хангамжийн хэсгийн аюулгүй ажиллагааны журмыг боловсруулан байгууллагын бүх ажилчдад танилцуулсан ба хүчилтөрөгчийн хийн баллонтой ажиллах зааварчилгааг өгч ажиллаж байна.<br>Хүчилтөрөгчийн хийн хангамжийн байрыг тогтмол цоожтой байлгаж, баллоны тэргэнцрээр зөөвөрлөхдөө баримтлах журмыг мөрдөж байна.<br>Мөн хүчилтөрөгчийн тасралтгүй бэлэн байдлыг хангаж тогмтол цэнэглэлтийг хийж байна. | 95 |
| | | Өндөр эрсдэл үүсгэх, ижил дуудагдах, гадна байдал нь ижил харагдах эмийн жагсаалтыг гарган батлуулж бүх тасаг нэгжид байршуулах, үүний дагуу бүх ажилчдад сургалт хийх, хэрэгжилтэнд хяналт хийж хэвших | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Эмийн аюулгүй байдал хангагдана | Өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эм, ижил дуудлагатай эм, тариа, сав баглаа боодол, шил нь ижил харагдахуйц эм тарианы жагсаалтыг гарган эмч сувилагч нарт мэдээллийг тогтмол өгч эрсдэлээс сэргийлэн ажиллахаас гадна, дээрх эрсдэлтэй эм тариаг хэрхэн үйл ажиллагаанд ажиглах талаар “Өндөр эрсдэл бүхий эм тариаг хэрэглэх журам”-ыг боловсржжлан гаргаж эмч сувилагч нарт хүргэж, мөн хүлээн авах тасагт байршуулан эрсдэлээс сэргийлэн ажиллаж байна. | 95 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | MNS5095;2017 стандартын дагуу Рентгены өрөөг тохижуулан аюулгүй байдлыг хангах /цацрагийн үүсгүүртэй рентген тоног төхөөрөмжийг ашиглах, хадгалах, тусгай зөвшөөрлийг мэргэжлийн хяналтын байгууллагаар гаргах, цацрагийн тунгийн хамжилтийг тогтмол хийлгэх/ | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Эмч эмнэлгийн ажилчид, үйлчлүүлэгч рентген туяаны хордлогоос сэргийлнэ | Дүрс оношлогооын эмчид холбогдох хууль тогтоомжийн дагуу нэмэгдэл хөлсийг бүрэн олгож ажиллаж байгаа болон өдрийн ажиллах цагийн зохицуулалтыг хийхдээ үзлэгийн цагийг богиносгосон. | 100 |
| | | Хийн хангамжийн нэгдсэн шугам даралтат сав хийн баллоны аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгнө. / хүчилтөрөгчийн баллон хадгалах, байрлуулах байрны аюулгүй байдлыг хангах, Хүчилтөрөгчийн баллон зөөж байгаа ажилтанд аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч тэмдэглэл хөтлөх, хяналт хийх, даралтат савны манометрийг баталгаажуулах, баллоныг хаягжуулах, баллон тээвэрлэх зөөвөрлөхдөө бэхэлгээтэй тэргэнцэр | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Үйлчлүүлэгч болон эмч эмнэлгийн ажилтаны дүүргийн иргэдийн амь нас эрүүл мэндийг эрсдэлээс хамгаална | Хүчилтөрөгчийн хийн хангамжийн бэлэн байдал болон цэнэглэлт тээвэрлэлтийг 2 ээлжийн жолооч хариуцан хийдэг ба жолооч нарыг хий хангамж хүчилтөрөгчтэй хэрхэн харьцах талаарх ажлын байрны сургалтад хамруулж тогтмол. аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгөн ажиллаж байна.<br>2024 онд хүчилтөрөгчийн хийн хангамжид аюжлгүй ажиллагааг хангаж хүчилтөрөгчийн баллон бүрт гадуур нь даавуун уут хийж, хүзүүвчээр нь сайтар бэхэлж өгсөн байна мөн хүчилтөрөгч тээвэрлэхдээ бэхэлгээтэй тэргэнцэртэй болох захиалга өгөөд байна. | 95 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эсвэл тусгай зориулалтын тэргэнцэр дээр тээвэрлэх, даралтат савыг ажиллуулсан үедээ тэмдэглэл хөтлөх/ | | | | | | |
| | | Цус цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглэх тогтолцоог бүрдүүлэх үүнд: ЭМСайдын 2017 оны А/03 тоот тушаалыг хэрэгжүүлэн ЦЦБний хэрэглээг зохицуулах, эмч эмнэлгийн ажилчдыг сургалтанд хамруулах, аюулгүй байдлыг хангах ЭМСайлын 2018/12/07 А/506 тоот тушаалын дагуу ЦЦБ-ний бэлэн байдлыг хангах | Жилдээ | Жилдээ | Жилдээ | Цус цусан бүтээгдэхүүний эрх зүйн бичиг баримт бүрдэж, ЦЦБ-ний хэрэглэх аюулгүй нөхцөл байдал бүрдэнэ | Цус цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглэх тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд ЭМСайдын 2017 оны А/03 тоот тушаалыг эмч, сувилагч нарт танилцуулан, 1 удаагийн сургалтыг хийсэн. Үүнд 2 эмч, 3 сувилагч хамрагдсан байна.<br>ЭМСайдын 2018/12/07 А/506 тоот тушаалыг эмч эмнэлгийн ажилчдад танилцуулж шаардлагатай тохиолдолд цус цусан бүтээгдэхүүнээр хангах тусламж үйлчилгээг зохицуулах журам боловсруулан байгууллагын даргаар батлуулан эмч сувилагч, эмнэлгийн ажилчдад танилцуулан ажилласан. | 95 |
| | | Дундаж хувь | | | | | | 98.5% |

ХЯНАСАН
ДАРГА Х.ГАНБАТ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН
ЧАНАРЫН МЕНЕЖЕР Г.ОЮУНДУЛАМ